



ТАНИЛЦУУЛГА

МАК КОНКРИТ БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭР

МАК Конкрит бетон зуурмагийн үйлдвэр нь Бүгд Найрамдах Турк улсын ELKON брэндийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, Япон улсын Aizawa группийн компьютерын хяналт бүхий бүрэн автомат технологи, арга туршлагын дагуу үйлдвэрлэл явуулж байгаа бөгөөд Японы Аж Үйлдвэрийн Стандартад (JIS) нийцсэн үйлдвэр юм.

Япон улс нь газар хөдлөлтийн эрсдэл ихтэй байдгаас шалтгаалан бетон зуурмагт өндөр стандарт тавьж хамгийн сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг тул Монголын Алт МАК компани 2023 онд Aizawa групптэй хамтран япон стандартын үйлдвэрийг байгуулаад байна. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд бид M150 - M650 маркийн бетон зуурмаг үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлж буй бөгөөд цаашид Монгол Улсын хэрэгцээ шаардлагаас хамааран M1000 хүртэлх өндөр чанарын зуурмаг үйлдвэрлэх зорилт тавиад байна.



МАК КОНКРИТ БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭР

МАК Бетон зуурмагийн үйлдвэр нь цагт 150м³ бетон зуурмаг зуурах хүчин чадалтай. Зуурагч машин нь нэг удаад 4м³ багтаамжаар зуурна. Мөн барилгын талбай бүрийн онцлог, цутгалт хийх үеийн цаг уурын байдал, тээвэрлэлтийн хугацаа зэргийг харгалзан, хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн орц найрлагаа тохируулан хамгийн найдвартай, шинж чанарын өөрчлөлтгүй бүтээгдэхүүнийг санал болгож байна. Тэр дундаа Монголын барилгын салбарын хамгийн тулгамдсан асуудал болох хүйтний улиралд барилга угсралтыг үргэлжлүүлэхэд шаардлагатай их хэмжээний бетон зуурмагийг тасралтгүй нийлүүлэх боломжийг бүрдүүлсэн гэдгээрээ онцлог юм.

НЭМЭЛТИЙН ТҮГЭЭМЭЛ ТӨРЛҮҮД

– Усны зарцуулалтыг багасгах нэмэлт

Энгийн бетонд ихэвчлэн ашигладаг. Шинээр бэлтгэсэн бетон зуурмагийн шинж чанарт нөлөөлж, бетон цутгах ажиллагааг хялбар болгоход тусалдаг.

– Усны зарцуулалтыг их хэмжээгээр багасгах нэмэлт

Энэ төрлийн нэмэлтийг ихэвчлэн онцгой төрлийн бетон болон өндөр маркийн бетонд ашигладаг.

– Удаашруулагч

Бетоны эхэн үеийн барьцалдах хугацааг багасгадаг. Ихэвчлэн хол тээвэрлэх бетонд ашигладаг.

– Түргэсгэгч

Бетоны эхэн үеийн барьцалдах хугацааг ихэсгэдэг. Өвлийн бетонд хамгийн түгээмэл ашигладаг.

– Агаар оруулагч

Маш жижиг хэмжээтэй зөв агаарыг бетон зуурмагт оруулснаар бетоны ажиллах чадвар сайжирдаг.

– Унтуулагч

Цементийн гидратацын урвалын хөдөлгөөнийг түр зогсоож эсвэл хэдэн цагийн туршид бетоныг бэхжүүлэлгүй хадгалдаг химийн хлоргүй нэмэлтийн систем юм. Хоолой, газар доорх бүтээц, түр зуурын дэмжлэг хийх бүтээц, бүтээцийн засвар зэрэгт ихэвчлэн ашигладаг.



БЕТОНЫ МАРКИЙН ТӨРЛҮҮД, ХЭРЭГЛЭЭ

Бетоны марк гэдэг нь 15х15х15 см хэмжээтэй сорьц-шоонуудын шахалтын бат бэхийн дунжийг кгх/см²-аар илэрхийлсэн нормчилсон үзүүлэлт юм. Харин бетоны анги гэдэг нь 15х15х15 см хэмжээтэй сорьц-шоонуудын бат бэхийг тодорхой магадлалтайгаар, МПа(Н/мм²)-аар илэрхийлсэн, нормчилсон үзүүлэлт юм. Эдгээр үзүүлэлтийг харгалзан тус хэрэглээг доорх хүснэгтийн дагуу тогтоосон байдаг.

Анги (В) МПа	Марк (М) кг/см ²	Зориулалт хэрэглээ
В7.5	М100	Ул бетон, тэгшилгээний зориулалттай даацын бус хийцэд ихэвчлэн хэрэглэнэ
В10-12.5	М150	
В15	М200	Барилгын даац, давхрын тоо зэргээс хамаараад голдуу амины зориулалттай барилга, орон сууц гэх мэт барилга байгууламжид ашиглана.
В20	М250	
В22.5	М300	Орон сууцны хороолол, худалдаа үйлчилгээний зориулалттай болон олон давхар барилга байгууламжийн суурь, үндсэн багана, дам нуруу зэрэг хийцлэлүүдэд голдуу ашиглана.
В25	М350	
В30	М400	
-	М450	Эмнэлэг, цахилгаан станц, зам гуур, төмөр замын дэр бетон, гүүрний дам нуруу зэрэг дэд бүтцийн болон онцгой зориулалтын объект барихад ашиглана.
В40-45	М500-600	
Песко	М200	Даац авахгүй, өнгөлгөөний зориулалттай бетон зуурмаг ба дүүргэгчийн ширхэглэл нь 5-10 мм /дайрга, элс/
Мортар /00/	М150-М300	Мортар нь бетон шахуургат төхөөрөмжийн хоолой чийглэх, хар шалны тэгшилгээ өнгөлгөөнд ашиглана. Дүүргэгчийн хамгийн том ширхэгийн хэмжээ 5мм

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДАВУУ ТАЛ



БОРЛУУЛАЛТЫН УТАС: 7575-9700; 9595-0000

✉ makbm@mak.mn  makbm.mn

МАКВМ ТАЛААР
ДЭЛГЭРЭНГҮЙ
МЭДЭЭЛЭЛ:

